



Дээд Боловсролын Сургалт: Түр Оршин Суух Виз  
(Ангилал 573)  
Үнэлгээний Түвшин 3

АВСТРАЛИ УЛСААС ГАДНА (Offshore) МЭДҮҮЛЭГ ӨГЧ БУЙ  
МОНГОЛ УЛСЫН МЭДҮҮЛЭГЧИД

Бүрдүүлэх Материалын Жагсаалт

Энэхүү жагсаалтад сургалтын мэдүүлэг өгөхөд хэрэгтэй мэдээлэл болон шаардагдах бичиг баримт багтана. Түүнчлэн хувь хүний байдлаас хамааран шаардагдаж болзошгүй илүү бичиг баримтыг мөн жагсаасан байгаа.

Анхаарвал зохих зүйлс:

- Доор дурдагдах бичиг баримтуудын хуулбарыг ирүүлэх
- Гадаад паспортаас бусад бичиг баримтын эх хувийг ирүүлэхгүй байх
- Албан ёсны бичиг баримтуудыг нотариатаар баталгаажуулсан байх
- Монгол хэл дээрх бүх бичиг баримтыг баталгаат орчуулгаар Англи хэлрүү хөрвүүлсэн байх
- Энэхүү жагсаалыг бүрэн гүйцэд бөглөн мэдүүлэгийн материалын дээд талд хавсаргах

| МЭДҮҮЛЭГИЙН МАЯГТ БОЛОН ХУРААМЖ  | (√)                      |
|--|--------------------------|
| Сургалтын мэдүүлэг өгөх бол доорх мэдүүлэгийн маягтуудыг Англи хэл дээр бүрэн гүйцэд бөглөсөн байна.<br><br><a href="http://www.immi.gov.au/allforms/pdf/157a.pdf">Маягт 157А - Сургалтын виз мэдүүлэг (түр оршин суух)</a><br><a href="http://www.immi.gov.au/allforms/pdf/157a.pdf">http://www.immi.gov.au/allforms/pdf/157a.pdf</a>   | <input type="checkbox"/> |
| <a href="http://www.immi.gov.au/allforms/pdf/54.pdf">Маягт 54 - Гэр Бүлийн Гишүүдийн Жагсаалт</a><br><a href="http://www.immi.gov.au/allforms/pdf/54.pdf">http://www.immi.gov.au/allforms/pdf/54.pdf</a>   | <input type="checkbox"/> |
| <a href="http://www.immi.gov.au/allforms/pdf/956.pdf">Маягт 956 - Цагаачлалын агентлаг болон зөвшөөрөлтэй эрх бүхий этгээд</a><br><a href="http://www.immi.gov.au/allforms/pdf/956.pdf">http://www.immi.gov.au/allforms/pdf/956.pdf</a> Зөвхөн цагаачлалын агентлагаар дамжуулж мэдүүлэг өгөх эсвэл таны мэдүүлэгийн талаар мэдээлэл авах эрх бүхий этгээдийг сонгосон тохиолдолд бөглөнө. | <input type="checkbox"/> |
| Виз мэдүүлэгийн хураамж<br>Хураамжыг Цагаачлал болон Иргэншил Хариуцсан Албанд (DIAC) зөвхөн бэлэн мөнгөөр (ЮАНЬ) эсвэл Хятадын шуудангын гуйвуулгаар дамжуулан төлөх боломжтой. Хураамжын талаарх дэлгэрэнгүйг <a href="http://www.china.embassy.gov.au/bjng/DIACtemp.html">http://www.china.embassy.gov.au/bjng/DIACtemp.html</a> -д орж авна уу.  | <input type="checkbox"/> |

| <b>ХУВИЙН БИЧИГ БАРИМТУУД</b>  | <b>(√)</b>               |
|--|--------------------------|
| Паспортын хэмжээтэй (45мм x 35мм) зураг 4 хувь <ul style="list-style-type: none"> <li>• Зураг нь өнгөгүй дэвсгэр дээр авсан байх ба толгой мөрийг гаргасан байна</li> <li>• зураг бүрийн ар талд мэдүүлэгчийн нэрийг Англиар бичсэн байна</li> </ul>                                     | <input type="checkbox"/> |
| Иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар   | <input type="checkbox"/> |
| Мэдүүлэг өгч буй хүн тус бүрийн гадаад паспортын нотариатаар баталгаажуулсан хуулбар. Гадаад паспорт хүчинтэй байх ёстой. Хэрэв та Цагаачлал болон Иргэншил Хариуцсан Албанд (DIAC) өөрийн биеэр ирэх шаардлага гарвал гадаад паспортоо авч ирнэ.  | <input type="checkbox"/> |
| Та болон таны Монголд үлдэж буй гэр бүлийн гишүүдийн хоорондын хамаарлыг нотлох баримт, үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Гэрлэлтийн Гэрчилгээ болон Төрсний Гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар</li> </ul>  | <input type="checkbox"/> |
| Хэрэв та хамтран амьдрагчтай бол хамгийн багадаа 12 сарын турш хамтран амьдарсанг нотлох баримт ирүүлэх шаардлагатай, жишээ нь: хамтран эзэмшдэг банкны данс, хамтран эзэмшдэг хөрөнгө, хамтран төлсөн ахуйн хэрэглээний хураамж, хамтран амьдардагыг батлах бусад бичиг баримт гэх мэт. | <input type="checkbox"/> |
| Хэрэв та гэрлэлтээ цуцлуусан, байнгын тусгаарлагдсан эсвэл бэлэвсэрсэн бол гэрлэлт цуцалсан гэрчилгээ, эсвэл эхнэр/нөхрийн нас барсан гэрчилгээг (хэрэв ирүүлэх боломжтой бол) ирүүлнэ.  | <input type="checkbox"/> |
| Хэрэв мэдүүлэг өгч буй хэн нэгний нэр өөрчлөгдсөн бол доорх бичиг баримтыг ирүүлнэ, үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• нэр өөрчлөсөн тухай албан бичигийн нотариатаар баталгаажуулсан хуулбар</li> </ul>   | <input type="checkbox"/> |
| Мэдүүлэг хамт өгч буй тэжээлгэгч үр хүүхдийн хэн нэгэн нь өргөмөл бол, өргөж авсан тухай албан бичигийн нотариатаар баталгаажуулсан хуулбар.   | <input type="checkbox"/> |
| Мэдүүлэгчийн 18 нас хүрээгүй хүүхдийн асран хамгаалалын талаарх албан бичигийн нотариатаар баталгаажуулсан хуулбар. Хэрэв эцэг эх хоёр нь эсвэл асран хамгаалагч нь хамт мэдүүлэг өгч буй бол дээрх бичиг баримт шаардлагагүй.   | <input type="checkbox"/> |
| Хэрэв мэдүүлэгчийн гэр бүлийн гишүүд 5 нас хүрсэн боловч 18 нас хүрээгүй бөгөөд мэдүүлэгчтэй хамт Австралид оршин суух тохиолдолд Австралийн дунд сургуулид бүртгүүлсэн талаарх баримт ирүүлнэ, мөн үүнтэй холбогдох сургалтын төлбөр төлөгдсөн байх ёстой.                              | <input type="checkbox"/> |

| <b>ЭРҮҮЛ МЭНДИЙН ШААРДЛАГУУД</b>   | <b>(√)</b>               |
|--|--------------------------|
| Бид мэдүүлэгийн материалыг хүлээн авч хянан шалгасны дараа таньд эрүүл мэндийн шинжилгээ хийлгэх шаардлагатай эсэхийг мэдэгдэнэ. Түүнээс өмнө эрүүл мэндийн шинжилгээ хийлгэхгүй байхыг анхаар. Эрүүл мэндийн шинжилгээнд эрүүл мэндийн үзлэг болон цээжин биеийн X-Ray шинжилгээ багтана. | <input type="checkbox"/> |
| Дэлгэрэнгүйг <a href="http://www.immi.gov.au/allforms/health-requirements/">Эрүүл Мэндийн Шаардлага http://www.immi.gov.au/allforms/health-requirements/</a> -д орж авна уу.   |                          |

| <b>БУСАД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАН ЧАНАРЫН ШААРДЛАГУУД</b>  |  | (√)  |
|---|--|--|
| Австрали улсад суралцах хугацаандаа хэрэглэх эрүүл мэндийн даатгал хийлгэсэнг нотлох баримт   |  | <input type="checkbox"/>                                 |
| Таны мэдүүлэгийн материалыг хянан шалгаж буй цагаачлалын албанаас доорх бичиг баримт шаардлагатай эсэхийг таньд мэдэгдэнэ.<br><br>Та 16 нас хүрсэнээс хойших сүүлийн арван жилд ямар нэгэн улсад 12 сар болон түүнээс дээш хугацаагаар оршин суусан бол тухайн улсаас авсан цагдаагын тодорхойлолтыг ирүүлнэ.<br><br>Хэрэв та ямар нэгэн улсад цэргийн алба хаасан бол нотолгоо болох баримтыг ирүүлнэ. |  | <input type="checkbox"/><br><br><input type="checkbox"/> |

| <b>БОЛОВСРОЛЫН БИЧИГ БАРИМТУУД</b>   |   | (√)                      |
|--|---|--------------------------|
| Таны Австрали улсад суралцахаар сонгосон хөтөлбөр(үүд)-ийг жагсаасан Сургуулийн Урилга.  |   | <input type="checkbox"/> |
| Хэрэв та дээд боловсролын сургалтаа эхлэхээс өмнө Англи хэлний хөтөлбөрт (эсвэл Англи хэлний бэлтгэлд) хамрагдах шаардлагатай бол 30 долоо хоногоос доош хугацаанд Англи хэл суралцах тухай Сургуулийн Урилга ирүүлнэ. |   | <input type="checkbox"/> |
| Доорх (a), (b), (c) ог (d) -н <b>аль нэгийг</b> заавал ирүүлнэ.  |   |                          |
|  | a.) 12 жилийн (эсвэл үүнтэй тэнцэх) бүрэн дунд боловсрол эзэмшсэн гэх боловсролын гэрчилгээ.  | <input type="checkbox"/> |
| эсвэл  | b.) Хамгийн багадаа 11 жилийн бүрэн дунд боловсрол эзэмшсэн гэх боловсролын гэрчилгээ, энэ тохиолдолд Австрали улсад дээд боловсролын өмнөх бэлтгэл хичээлд хамтрагдсан байх эсвэл бэлтгэл хичээлд хамрагдах тухай Сургуулийн Урилгатай байх. | <input type="checkbox"/> |
| эсвэл  | c.) Австралийн Мэргэжилийн Сургалтын Сертификат IV Зэрэг эсвэл түүнээс дээш зэргээр Австрали улсад суралцсанг нотлох боловсролын гэрчилгээ.   | <input type="checkbox"/> |
| эсвэл  | d.) Австрали улсад сонгосон дээд мэргэжлээрээ суралцахаас өмнө Австралийн Мэргэжилийн Сургалтын Сертификат IV Зэрэг эсвэл түүнээс дээш зэргээр суралцах тухай Сургуулийн Урилгатай байх.  | <input type="checkbox"/> |

| <b>АНГЛИ ХЭЛНИЙ ТҮВШИН</b>  |   | (√)                      |
|---|---|--------------------------|
| Доорх сонголтуудын <b>аль нэгийг</b> заавал ирүүлнэ.                                    |   |                          |
| Хэрэв та 18 нас хүрээгүй бол (a), (b) эсвэл (c) сонголтуудын аль нэгийг заавал ирүүлнэ. |   |                          |
|   | a) IELTS шалгалтын гэрчилгээ<br>IELTS шалгалтын оноо: <ul style="list-style-type: none"> <li>▪ 6.0 эсвэл дээш оноотой бол дээд боловсролын сургалтад шууд хамрагдана</li> <li>▪ 5.5 оноотой бол бэлтгэл хичээлд хамрагдах тухай Сургуулийн Урилга ирүүлнэ; эсвэл</li> <li>▪ 5.0 оноотой бол 30 долоо хоногоос доош хугацаанд Англи хэлний хичээлд хамрагдах тухай Сургуулийн Урилга ирүүлнэ.</li> </ul> | <input type="checkbox"/> |

|       |   |                          |
|-------|---|--------------------------|
|       | <b>Анхаар:</b> Хоёр жил болон түүнээс өмнөх IELTS шалгалтын оноог хүлээж авахгүй.   |                          |
| эсвэл | б) Доорх байгууллагуудын аль нэгнээс бүрэн санхүүжүүлэх тухай мэдэгдэл: <ul style="list-style-type: none"> <li>▪ Мэдүүлэгчийн өөрийн улсын засгын газар</li> <li>▪ Олон улсын байгууллага (жишээлбэл: Дэлхийн Банк)</li> <li>▪ Австрали Улсын Засгын Газар</li> <li>▪ Австрали Улсын Бүсийн эсвэл Мужын засгын газар</li> </ul> | <input type="checkbox"/> |
| эсвэл | с) Виз мэдүүлэхээс хамгийн ихдээ 24 долоо хоногын өмнө Австрали улсад бүрэн дунд сургууль төгссөн гэх боловсролын гэрчилгээ, дүнгийн жагсаалт.  | <input type="checkbox"/> |
| эсвэл | d) Виз мэдүүлэхээс хамгийн ихдээ 2 жилийн өмнө Австралийн Мэргэжилийн Сургалтын Сертификат IV Зэрэгт чиглэсэн хөтөлбөрт Австралийн сургалтын визтэйгээр хамрагдаж хичээлийн ихэнх хувийг дүүргэсэнг нотлох боловсролын гэрчилгээ.<br><br><b>Анхаар:</b> Дээрх нөхцөлд бэлтгэл сургалт хамаарагдахгүй.                           | <input type="checkbox"/> |
| эсвэл | e) Виз мэдүүлэхээс хамгийн ихдээ 24 долоо хоногын өмнө Австрали улсад бэлтгэл сургалтад хамрагдсан гэх боловсролын гэрчилгээ, дүнгийн жагсаалт.   | <input type="checkbox"/> |
| эсвэл | f) Австрали, Канад, Шинэ Зеланд, Ирланд, Англи, Америк болон Өмнөд Америк зэрэг улсуудад 5 жил эсвэл дээш хугацаанд Англи хэл дээр суралцсан гэх боловсролын гэрчилгээ, дүнгийн жагсаалт.   | <input type="checkbox"/> |

| <b>САНХҮҮГИЙН БИЧИГ БАРИМТУУД</b>  |                          | (√) |
|--|--------------------------|-----|
| Та Австралид суралцах эхний <b>24 сарын</b> зардал болон гэр бүлийн гишүүдийнхээ мөн хугацааны амьжиргааны өртгийг даах хангалттай хөрөнгөтэй гэдгээ нотлох баримт ирүүлнэ, үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• амьжиргааны өртөг</li> <li>• сургалтын төлбөр</li> <li>• сургуулийн насны хүүхэдийн сургалтын төлбөр</li> </ul>   | <input type="checkbox"/> |     |
| Хэрэв та үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй бол дээр дурдагдсан өртгүүдийг цаашид даах хангалттай хөрөнгөтэй гэдгээ бидэнд нотлох ёстой.<br><br><b>Анхаар:</b> Та өөрийн мэдүүлэгтээ хавсарган ирүүлсэн хөрөнгийн баталгааг Австрали улсад очсоны дараа аялал, сургалт, амьжиргаа өртөг болон ар гэрийнхэндээ зарцуулах бүрэн эрхтэй гэдэгийг манай цагаачлалын албанд нотлон харуулах хэрэгтэй. | <input type="checkbox"/> |     |
| Та Австрали улсруу зорчих бас буцаж ирэх замын зардалдаа зориулах хангалттай хөрөнгөтэй байх ёстой.  | <input type="checkbox"/> |     |
| Мэдүүлэгчийн орлого болон мөнгөн хадгаламжыг баримтаар нотолгоожуулах. Хэрэв мэдүүлэгч ажил эрхэлдэг бол ажил олгогчын гарын үсэгтэй ажлын тодорхойлолт ирүүлнэ. Тодорхойлолтод мэдүүлэгч ямар албан тушаалд ажилладаг, ажилласан хугацаа, цалин болон ажил олгогчтой холбоо барих мэдээллүүд багтсан байна.   | <input type="checkbox"/> |     |
| Мэдүүлэгчийн эцэг/эх эсвэл санхүүжүүлэгчийн гарын үсэгтэй албан ёсны мэдэгдэл ирүүлнэ. Үүнд мэдүүлэгч болон санхүүжүүлэгч нь ямар харилцаа холбоотой талаар  |                          |     |

|  |                          |
|--|--------------------------|
| дурьдсан байна. Тухайн этгээд нь мэдүүлэгчийг Австрали улсад суралцах хугацаанд санхүүжүүлнэ гэдгээ мэдэгдэж холбоо барих бүрэн мэдээллийг (оршин суух хаяг, шуудангыг хаяг болон утасны дугаар) мэдүүлэгтээ багтаасан байна.  | <input type="checkbox"/> |
| <a href="http://www.immi.gov.au/students/students/573-3/financial.htm">Санхүүгийн Бичиг Баримтын</a> талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй <a href="http://www.immi.gov.au/students/students/573-3/financial.htm">http://www.immi.gov.au/students/students/573-3/financial.htm</a> -д орж танилцаарай. |                          |

| <b>ХӨРӨНГИЙН БАТАЛГАА</b>   | <b>(√)</b> |
|---|------------|
| Доор дурдагдах бичиг баримтуудаас сонгон аль <b>нэгийг</b> нь ирүүлнэ үү:   |            |
| <p>а) Мөнгөн хадгаламж, энэ нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Банк санхүүгийн байгууллагаас гаргасан байх ба <ul style="list-style-type: none"> <li>- Банкны данс нь таны эсвэл өөр ямар нэгэн этгээдийн нэр дээр байна <input type="checkbox"/></li> <li>- Мөнгөн хадгаламж нь виз мэдүүлэг өгөхөөс өмнө дор хаяж <b>3 сарын</b> өмнө дансанд хөдлөлгүй байршсан байх ёстой. <input type="checkbox"/></li> </ul> </li> </ul> <p>Хэн нэгэний нэр дээрх банкны хадгаламжын мөнгөн хөрөнгө нь үнэлгээний гуравдугаар түвшингийн мэдүүлэг өгөхөөс өмнө хамгийн багадаа 3 сарын турш дансанд байршсанг нотлох баримт, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Банкны Тодорхойлолт - хуримтлуулсан мөнгөн хөрөнгө нь мэдүүлэг өгөх үед тухайн дансанд байрлаж буйг харуулна; Мөн <input type="checkbox"/></li> <li>- Банкны хадгаламжын дэвтэр <input type="checkbox"/></li> </ul> <p>Анхаар: Хэрэв та хичээлийнхээ 75%-г амжилттай дүүргэсэн бөгөөд тухайн мэргэжилээ дуусгахын тулд сургалтын виз мэдүүлж буй тохиолдолд дээрх 3 сарын мөнгөн хадгаламж шаардлагагүй. <input type="checkbox"/></p> |            |
| <p>b) Сургалтын Зээл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Банк санхүүгийн байгууллагаас олгосон байна <ul style="list-style-type: none"> <li>- Зээл нь мэдүүлэгчийн нэр дээр эсвэл өөр ямар нэгэн этгээдийн нэр дээр олгогдсон байх ба зээлийн гол зорилго нь мэдүүлэгчийг Австрали улсад суралцахад чиглэгдсэн байх ёстой. <input type="checkbox"/></li> </ul> </li> </ul> <p>Зээлийн Гэрээг баталгаат орчуулгын төвөөр Англи хэлрүү хөрвүүлсэн байна.</p>  |            |
| <p>c) Сургалтын Зээл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зээл нь мэдүүлэгчийн улсын засгын газараас олгогдон байна. Зээл олгосонг нотлох баримт ирүүлнэ.. <input type="checkbox"/></li> </ul>   |            |
| <p>d) Сургалтын Тэтгэлэгт Хөтөлбөр эсвэл Санхүүгийн Тусламж, доорх байгууллагаас олгосон байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэдүүлэгчийн Улсын Засгын Газар <input type="checkbox"/></li> <li>• Ямар Нэгэн Өөр Улсын Засгын Газар <input type="checkbox"/></li> <li>• Олон Улсын Байгууллага <input type="checkbox"/></li> <li>• Хуулийн Байгууллага (Ротариа Олон Улсын Байгууллага, Форд Нийгэмлэг Үндэсний Улаан Загалмай Нийгэмлэг) <input type="checkbox"/></li> <li>• Австрали Улсын Засгын Газар <input type="checkbox"/></li> <li>• Австралын Мужын Засгын Газар <input type="checkbox"/></li> <li>• Хүлээн Зөвшөөрөгдсөн Ашгын Бус Байгууллага <input type="checkbox"/></li> </ul>  |            |

| <b>ОРЛОГЫН БАТАЛГАА</b>   |  | (√)                      |
|---|--|--------------------------|
| Доорх бичиг баримтуудыг ирүүлнэ (таны нөхцөл байдалд тохирч буйг сонго) |  |                          |
| a.  | Татварын Баримт  | <input type="checkbox"/> |
| b.  | Орлогын Баримт   | <input type="checkbox"/> |
| c.  | Нийгмийн Даатгалын Дэвтэр                                  | <input type="checkbox"/> |
| d.  | Бизнесийн Гэрчилгээ  | <input type="checkbox"/> |
| e.  | Зээлийн Бичиг Баримт                                       | <input type="checkbox"/> |
| f.  | Банкны тодорхойлолт  | <input type="checkbox"/> |
| g.  | Мөнгөн хөрөнгийн хадгаламж эсвэл ямар нэгэн орлогын баримт | <input type="checkbox"/> |

| <b>18 НАС ХҮРЭЭГҮЙ МЭДҮҮЛЭГЧИЙН АСРАН ХАЛАМЖЛАЛЫН АСУУДАЛ</b>   |  | (√)                      |
|---|--|--------------------------|
| Хэрэв мэдүүлэгч 18 нас хүрээгүй бол түүнд хуулийн дагуу хариуцлага хүлээгч хүн бүр түүнийг Австрали улсад суралцахад бүрэн зөвшөөрч буйгаа мэдэгдэх ёстой |  | <input type="checkbox"/> |
| Хэрэв мэдүүлэгч 18 нас хүрээгүй бол (a), (b) эсвэл (c) аль нэгэнд тохирох нотолгоо баримт бичиг ирүүлнэ   |  |                          |
|   | a.) Хэрэв мэдүүлэгчийн эцэг/эх эсвэл арсан халамжлагч нь түүнтэй хамт Австрали улсад амьдрах бол тэд нарын хоорондох харилцаа холбоог илтгэх нотолгоо бичиг баримт ирүүлнэ. Мөн тухайн асран халамжлагч нь мэдүүлэгчийг Австрали улсад суралцах нийт хугацаанд эсвэл түүнийг 18 нас хүртэл хуулийн дагуу хамт оршин суух эрхтэй гэдгийг нотлох баримт шаардлагатай.  | <input type="checkbox"/> |
| эсвэл   | b.) Мэдүүлэгчийн эцэг/эхийн зөвшөөрлийн дагуу ямар нэгэн хамаатан садан түүнийг Австрали улсад суралцах хугацаанд нь асран халамжлах бол тухайн халамжлагч дараах бичиг баримтыг ирүүлнэ, үүнд: хамаатан садан гэдгийг нотлох бичиг баримт, асран халамжлагч 21 нас хүрсэнг илтгэх бичиг баримт, цагдаагын тодорхойлолт, асран халамжлагч мэдүүлэгчийг Австрали улсад суралцах нийт хугацаанд эсвэл түүнийг 18 нас хүртэл Австрали улсад оршин суух эрхтэйг илтгэх бичиг баримт гэх мэт. Цагдаагын тодорхойлолттой холбоотой дэлгэрэнгүйг мэдээлэл авах боломжтой.<br><br><u>Зан Чанарын Шаардлага болон Цагдаагын Тодорхойлолт</u> -той танилцана уу. | <input type="checkbox"/> |
| эсвэл   | c.) Хэрэв мэдүүлэгч нь Австрали улсад суралцах хугацаанд дээр дурдсан хүмүүсийн асрамжинд байхгүй бол мэдүүлэгчийг уриж буй тухайн сургуулиас түүнийг Австрали улсад суралцах хугацаанд холбогдох байр болон халамжын асуудалыг хариуцана гэсэн мэдэгдэл ирүүлэх шаардлагатай.<br><br>Шаардлагат хэрхэн нийцэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 18 нас хүрээгүй суралцагчид - шаардлагатай нэмэлт материал- д орж танилцана уу.  | <input type="checkbox"/> |